

## УЛАМЖЛАЛТ АНАГААХ

### Монгол анагаах ухаан ба дом заслын үүсэл хөгжил

*Наранзаяа Л.<sup>1</sup>, Анхцацрал Л.<sup>1</sup>, Улаан-Од Х.<sup>2</sup>,  
Сайжрах Б.<sup>1</sup>, Буянт Б.<sup>1</sup>, Болд Ш.<sup>3</sup>*

*<sup>1</sup>Өвөр Монголын үндэстний их сургууль, <sup>2</sup>“Ач” Анагаах ухааны их сургууль,  
<sup>3</sup>Монголын анагаах ухааны академи  
Email: naranzaya@ach.edu.mn*

#### Abstract

#### Traditional Mongolian medicine and origins of Dhom remedy

*Naranzaya L.<sup>1</sup>, Ankhtsatsral L.<sup>1</sup>, Ulaan-Od Kh.<sup>2</sup>, Saijirahu B.<sup>1</sup>, Baoyintu B.<sup>1</sup>, Bold Sh.<sup>3</sup>*

*<sup>1</sup>“Inner Mongolia University for Nationalities”, <sup>2</sup>“Ach” Medical University,  
<sup>3</sup>Mongolian Academy of Medical Science  
Email: naranzaya@ach.edu.mn*

#### Background

Traditional Mongolian medicine is one of the heritage which inherited since ancient times of nomadic culture. The radical culture of Mongolian medicine is related to shamanism and initially, it was inherited as “Dhom zasal” among folks and it was written and popular as “Sutra of Dhom” and “Sutra of Black Dhom”.

Thus, to define the fundamental knowledge and methods of traditional cure by analysing from those scriptures like, sutras and fetishism is the unavoidable and historical duties for the contemporary medical researchers. Therefore, our mission was to study and recognize the historical facts of the reason, situation and the generative factors of birth of remedies.

#### Material and Method

We used following study methods; manuscripts, primary source methods, hermeneutic method, and historical comparative method.

The study materials were more than 20 sutras which have not studied fully. Furthermore, we used scientist’s creatures and textbooks related to dhom zasal.

#### Results

It is important for define that, in which developmental period of Mongolian traditional medicine, the mantic cure was formed and what it has been through to be inherited nowadays. If could do so, it would be more accessible and orderly.

Recently, our medical researchers have reached to substantial success in study of medical history and have come with conclusive result that the Mongolian traditional medicine has to be properly staged into six developmental periods.

Further, the researchers have identified not only developmental stages of traditional medicine, but defined stages of development of medical science in Mongolia.

Regarding to this developmental definition, formation of traditional remedies is belonged to the stage of observation-based curing technique collecting (from prehistoric to 209 AD) period.

#### Conclusion

From our study, based on resources and factual statements, we found that, Dhom in Mongolian means remedies which were initiated at primitive time due to their physical unwellness and improved and developed from time to time. In fact, at the beginning, the remedy methods were empirical, with no adequate sequences and involuntary, but it had been developed time by time throughout, experiment and observations.

**Key words:** Dhom, Dhom remedy, Traditional Mongolian medicine

Pp. 61-65, References 16

### Оршил

Нүүдэлчдийн үүдэн бүтээсэн олон төрлийн мэдлэг ухааны дотроос анагаах ухаан бол эрт үеэс өдийг хүртэл хадгалагдан уламжлагдан ирсэн өөрийн үндсэн онцлог бүхий өв соёлын нэг болно. Монгол анагаах ухааны язгуур соёл бол бөөгийн шашинтай холбоотой бөгөөд хамгийн анх “Дом засал” хэмээх нэрээр ардын дунд уламжлагдаж, үсэг бичгээр тэмдэглэгдэхдээ “Домын судар” буюу “Хар домын судар” хэмээн алдаршжээ [1]. Тиймээс монголын язгуур анагаах ухааны судар ном болох “Домын судар” буюу “Хар домын судар”-аас монгол эмнэлгийн язгуур заслын ухааныг ялгаруулан тодорхойлох нь монгол анагаах ухааны судлаач нарын зайлж болшгүй дархан ажил ба маш чухал түүхэн үүрэг болох юм. Тиймээс бид дом заслын үүссэн шалтгаан, нөхцөл, түүхэн хөгжилтэй холбоотой баримтуудыг судлан тогтоохыг зорьсон билээ.

### Зорилго

Дом заслын үүссэн шалтгаан, нөхцөл, монгол анагаах ухааны түүхэн хөгжилтэй холбоотой баримтуудыг судлан тогтоох, тайлбар, тайлал хийх.

### Материал, арга зүй

Бид энэхүү судалгаандаа герменевтик арга, эх бичиг, сурвалж бичиг судлалын арга, түүхэн харьцуулалтын аргууд ашигласан бөгөөд судалгааны материалд 20 гаруй домын судрууд, дом болон дом засалтай холбоотой эрдэмтдийн хийсэн судалгааны ном бүтээлүүдийг ашигласан болно.

Герменевтик арга: Бид энэхүү аргыг судалгаандаа монголчуудын бүтээн бий болгосон эртний эмчилгээний арга болон домын судрын агуулга, мөн чанар, бүтэц зохион байгуулалт уламжлалыг тодруулан гаргахад ашигласан.

Эх бичиг, сурвалж бичгийн судлал: Судалгаанд ашигласан хэрэглэгдэхүүнээ ажлынхаа зорилго, зорилтууддаа нийцүүлэн хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн түүхийн судалгааг хийж улмаар гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг, эргэлт гарахуйц санааг бусад эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгааж үзсэн.

Түүхэн харьцуулалтын арга: Уламжлалт анагаах ухааны янз бүрийн үед болсон үйл явдлуудыг төрөлжүүлэн хувааж хооронд нь харьцуулах, эмчилгээний онол арга зүй нэг үе шатнаас нөгөөд хэрхэн уламжлан дамжиж ирснийг

илрүүлэхэд энэхүү аргыг хэрэглэв.

### Үр дүн

Дом заслын үүссэн үеийг тогтоохдоо Монголын анагаах ухааны түүхэн хөгжлийн хэдий үед үүсэж, ямар ямар хөгжлийн үеүүдийг туулан эдүгээ хүрч ирснийг тогтоох нь чухал юм. Ингэж чадвал судлахад ойлгомжтой, эмх цэгцтэй болох учиртай.

Манай судлаачид сүүлийн жилүүдэд анагаах ухааны түүхийг судлах талаар багагүй амжилт олсны үр дүнд Монголын уламжлалт анагаах ухааны түүхийн үечлэлийг 6 үе шат болгон судлах нь илүү оновчтой хэмээн үзжээ. Мөн үе шат болгоны онцлогийг гаргах тусгай шалгууруудыг үечлэл болгоны дараа томъёолж өгсөн байна. Улмаар энэхүү үечлэлд үндэслэн гүнзгийрүүлэн судалж зөвхөн Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг бус ер нь Монголын анагаах ухааны хөгжлийг үечлэлийг тогтоосон байна.

Энэхүү үечлэлийн ёсоор Монгол домын үүссэн үе нь Ажиглалтанд тулгуурласан эмчилэхүй урлагийн мэдлэг бий болон туршлага хуримтлагдсан үе (Нэн эрт үеэс 209 он хүртэл) гэсэн эхний үед хамаарагдан орж байна.

Өдгөө Монгол домын судалгаа төдийлөн үгүйн дээр монгол дом бол Өрнөдийн судлаачдын үздэг домын аргаас анги өөр утга агуулгатай. Тиймээс бидний судалгааны ажил дом нь чухам яаж үүссэн, ямар ялгаатайг тогтоохоос эхэлсэн юм.

Монгол бол Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийн баян өв уламжлалтай улс бөгөөд түүний салшгүй хэсэг бол эмчилгээний дом засал мөн.

Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”-д “дом гэдэг нь хуучирсан эмчлэх, засах арга, эм дом, дом засал, хар дом” мөн “дом бол шашины ёсны чойрын сургууль төгсөхөд хийх баяр хурим (домын дамжаа барих, дом хийх) гэх зэрэг гэсэн байдаг .

Х.Дашзэвэг “Хаагдсан шүтлэг, нуугдсан сүсгийн сан хөмрөгөөс” шашины уламжлалт ёс, зан үйлийн толь номонд “Дом энэ нь шарын шашины ёслолд чойрын ном үзэж дуусаад, номын хурим хийдэг байсан байна. Үүнийг дом тавих, домын дамжаа барих гэж хэлдэг байв. Мөн өнө эрт монгол эмнэлгийг ингэж нэрлэдэг байв. Бас урьдын цагт эмгэг өвчнөө эдгээх гэж эм уухаас гадна элдвээр арга засал хийхийг эм дом хэрэглэх гэж хэлдэг байжээ”.

Дээрх хоёр тайлбар толинд монгол, төвөд үгийг

хооронд ижил мэт ойлгон хутгасан зүйл байх учир ялган салгах нь зүйтэй санагдана.

Төвөдийн дом монгол хэлний дом хоёр хоорондоо утгын хувьд эрс ялгаатай үгс. Монголоор ижил дуудагдана *sdon mo* гэж бичнэ. Орчуулбал баяр хурим гэсэн үг. Чойрын ном үзэж дуусгаад шарын шашины баяр хурим хийхийг хэлнэ. Харин манай монгол хэлний дом бол ёстой өнө эртний монгол эмнэлгийн нэр, урьдын цагт эмгэг өвчнөө эдгээх гэж эм уухаас гадна элдвээр арга засал хийхийг хэлдэг. Иймд энэ хоёр үгийг нэг бус хоёр өөр үг гэж салган тайлбарлах нь оновчтой болно. Монгол дом бол эмээр бус үйлдлээр засал хийхийн нэр. Дом заслыг хийдэг хүнийг домч гэнэ.

Эмчилгээний дом гэдэг нь бие махбодод ямар нэг хэмжээгээр нөлөөлж байдаг гэхдээ тэгэж нөлөөлдөгийн нууц нь тэр бүр бүрэн илрээгүй ардын анагаах арга. Эмчилгээний домын үйлчилгээний механизм тодорхой болоогүйн улмаас ид шид, далдын хүчинд итгэх төөрөгдөлд хүргэж болох онцлогтой байдаг.

Дом нь хүн төрөлхтний өнө эртний түүхэн нөхцөл дэх соёл, танин мэдэхүйн онцлогтой холбоотой тул түүнийг бидний өвөг дээдэс болох эртний хүний амьдрал, үйл явдлаас улбаалан тайлбарлаж болох юм.

Балар эртний үед нэг бүлийн сүрэг хүн арайхийн идэх юмтай болж, ангаа төхөөрч байтал өөр нэг бүлгийн сүрэг хүн хүч түрэн дайрч, идэш хоолыг нь булаах гэхэд амь өрссөн тулаан болж, тэд дийлсэн ч олон хүн шархдаж, үрэгдэж, шархтай нэгийгээ сувилж, тэнхрүүлэхээр илж, барьж, цус тогтоож боох тусламжийг бие биендээ хийж, тэр үеийн хүнд тохиолддог аюул хөнөөлийг багасгаж бууруулж болохыг илрүүлэн цаашид боловсронгуй болгон хөгжүүлж эхэлсэн байна.

Эртний хүний тулаан, тэмцэлтэй амьжиргааны түгшүүрт орчин нөхцөлд яс, мах тасарч, гэмтэж бэртэх, цус асгаран тэсэхүйеэ бэрх өвдөж шаналах, халуурч дэмийрэн, байх суух аргаа барьж ядахдаа шархаа долоох, алгаараа дарах, шархирч өвдсөн биеээрээ хад модонд шөргөөх, дарж хэвтэх, өөрийн эрхгүй хөдөлгөөн хийдэг тийм байгалийн авьяас, хамгаалах рефлексийн үйлдлүүд бол тэр цагийн хүмүүсийн дом байлаа. Хожим дом нь бариа засал гэдэг аргатай болж, домын нэг салбар үүсчээ.

Домын эх үүсвэр болох хамгаалах рефлексийн чадвар адгуус амьтанд ч байдаг. Чоно, нохой шархаа долоож, шархтай хандгай буга эмт ургамлын навч егүшин (нутгийн нэр нь хандгайн

шархны эм) дээр хэвтэж эдгэрдэг, хэрэм хөлөө хугарахад модны давирхайгаар шавдаг (чиг тавьдаг), хавханд орсон чоно хавхныхаа доод талаар хөлөө тас хазаж, хавхыг суга татаж орхиод явдаг зэрэг жишээ бий.

Хүн бол хамгаалах чадвартаа үндэслэн сэтгэж хөгжүүлсэн туршлагаа хуримтлуулж бусаддаа уламжилж чаддаг, оюун ухаанаараа бусдаас ялгаатай байдаг. Анхны эмчилгээний арга дом үүсэх эхэн үеийн түүхэн тойм ийм байсан буй.

Тэгэхлээр дом гэдэг нь: Балар эртний хүмүүсийн шархдаж, бэртэж, гэмтсэн үедээ түүнийг хэвийн байдалд нь оруулахаар авдаг арга хэмжээ, хөдөлгөөн, байгалийн авьяас, хамгаалах рефлексийн үйлдлүүдийг дом гэж үзэж болох байна. Энэхүү арга нь эхний үедээ империк шинжтэй, тогтсон дараалал, ухамсартай үйлдэл бус байсны хөгжлийн явцад, ажиглалт, туршилтаар боловсронгуй болж, хөгжсөөр байжээ.

Балар эртний хүний бүлээрээ сүрэглэн амьдардаг нөхцөл өөр болж, оюун ухааны хөгжил сайжирч, танин мэдэхүйн сэтгэлгээ нэмэгдсэний дүнд бүлээрээ сүрэглэж амьдардаг хүний амьдрал өөрчлөгдөж, бүлийн дотор хөдөлмөрийн хуваарь буй болж, эрэгтэйчүүд ан гөрөө хийх, сүргээ хамгаалахад давамгайлсан орж, отог нутгаа сахиж, хүүхдээ бойжуулахад эмэгтэй хүн илүү оролцох болсноор оромж, урьц сахьсан эмэгтэйчүүд хүүхдийн өвчнийг эмчлэх, жирэмсэн эмэгтэйг төрүүлэх, шархтанг сувилах зэрэг ажлыг гардан хийдэг болж, тэр цагаас эхлэн эмч, домч эмэгтэйчүүд олширч байсны сацуу монгол домд мэргэжлийн чиг ялгаа үүсээд дом-домч, эм-эмч, бариа-бариа, хануур- хануурч, засал-засалч, шарх-шархч гэдэг тусгай нэр томъёо бий болжээ.

Өнө эртний хүмүүс өвс ургамлыг хүнсний бэлэн бүтээгдэхүүн байдлаар хэрэглэж байсны дүнд зарим ургамал эдгэрүүлэх чадалтайг ажиглаж мэдээд, эм болгон эмчилгээнд хэрэглэх болсон цаг нь бариа заслаас их хойно үүссэн ажээ.

Эрүүл, өвчин, эдгээх гэсэн гурван үгийг эртний монголчууд эрүүл биеийг бүтэн, өвдсөн биеийг эвдэрсэн, эдгэрсэн биеийг зассан гэж ойлгодог байснаас улбаалан худам монголоор бичихдээ өвчтөн гэдгийг эвд+чин гэж бичдэг болсон сэтгэлгээний логик, танин мэдэхүйн тухайн үеийг илэрхийлсний баримт болж үлджээ. Эрүүл бие бүтэн юм бол өвдөхдөө эвдэрдэг, эвдэрсэн юм бол бүтэн болгохоор засна гэж сэтгэж өөр хоорондоо салашгүй утга уяалдаатай үйл явдлаас ухааран өгсөн нэр байж болно. Өөрөөр

хэлбэл засал гэсэн нэр бол бэртэл гэмтлийг эвлүүлэн барьж засна гэсний илэрхийлэл болно. Энэ утгаараа эм эмчилгээ гарахаас өмнө засал гэсэн нэр томьёо буй болсныг харуулдаг. Засал гэдэг нэр томьёо гарсан тэр цагт бэртэл их тохиолддог байснаас өвдөж зовохыг эвдэрлээ гэж ойлгодог байжээ.

Ийнхүү эмчилгээний домд мэргэжлийн салбарууд үүсч өргөжсөн тэр үеэс эмчилгээний дом түүхийн урт хугацаанд тэр чанараа хадгалсан байна.

Нүүдлийн аж амьдралтай эртний монгол туургатан бэлчээр нутгаа хайрлаж, байгалийн аясыг дагаж зохицон амьдардаг байсан хэмээн лус-уул, усны эзнийг аргадаж сүү, цайныхаа дээж өргөдөг ёс буй болсны сацуу хүмүүст газар нутгаа хайрлан хамгаалах, байгальд чин сэтгэлээсээ хандах хүмүүжил төлөвших нөхцлийг бүрдүүлсэн байна.

### Хэлцэмж

Ойрын жилүүдэд дом заслын сурвалж бичгийн судалгаа эрчимтэй явагдаж олон тооны дом судрыг цуглуулан эмхэтгэж, хураан хадгалж байгаа билээ. Тухайлбал Академич Ш.Болд эрдэмтний “Монголын уламжлалт анагаах ухааны түүх” мөн доктор Б.Пүрэвсүрэн гуайн “Монгол дом” хэмээх бүтээлүүдэд дом болон дом заслын тухай нэлээд өргөн хүрээг хамарч судалсан байсан нь бидний судалгааны ажилд их тулгуур болж өгсөн юм. Нүүдэлчин ардын эмнэлэг, соёлын ололт нь амьтны шууд, шууд бус нөлөө, мал маллах хөдөлмөрийн орчинд мал нь зориудаар биш ч яахын аргагүй туршилтын амьтны үүрэгтэй байсан нь аяндаа анагаах ухааны танин мэдэхүй хөгжихөд чухал ач холбогдолтой байжээ. Дом хүн үүссэн цагаас эхлэлээ тавьснаар бөөгийн шашинтай домын үүслийг холбох, бөө нар домыг үүдсэн мэт ойлгох нь дэндүү явцуу, хожмын ойлголт болох юм [2].

Монгол оронд бөөгийн шашин дэлгэрсэн тухайд Б.Ринчен, С.Бадамхатан, Х.Буянбат, Сүрбадрах, Енсон нар өөрсдийн саналаа илэрхийлсэн билээ. Тэдний үзэж буй нь үндсэндээ бөөгийн шашин хүй нэгдлийн үед тухайлбал, хуучин зэвсгийн үед үүсч бий болсон гэж үзэж байна. Харин шинэ чулуун зэвсгийн үе нь МЭӨ 5000-3000 жилийг хамарна.

Эртний хүмүүс малыг гаршуулан амьдрал ахуйдаа хэрэглэх болсон нь нүүдэлчдийн домын ухааныг хөгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн гэж үзэхээр байна. Монгол оронд мал

аж ахуй үүсч хөгжсөнөөр наад зах нь 5000 жил болсон гэж эрдэмтэн судлаачид тооцож байна (М.Төмөржав 1989, А.Я.Лус, С.Н.Боголовский нар 1959, Воронцов, 1972). Иймд Монголчууд Төв Азид амьдарч байсан нүүдэлчин олон овог, аймгийн нэгэн адил эрт дээр үед адгуусан амьтныг гэршүүлэн бэлчээрийн мал аж ахуйг бий болгон хөгжүүлэх явцад мал сүргээ адгуулан маллах, өсгөж үржүүлэхээс эхлээд эдлэж хэрэглэх, эмнэн анагаах ариун баялаг уламжлалт арга туршлага хуримтлуулсан байжээ.

Зэрлэг амьтныг гаршуулж гэрийн тэжээмэл мал бий болсон тэр цагт, хүн зөвхөн нарны элчинд дулдуйдан амьдарч байсан цагаас ангижирч, мал амьтны биеийн дулааныг эрүүл мэндэд зориулан ашиглах сэтгэлгээ бий болсон байна. Эл заслын тухай 2000 жилийн тэртээх Хятадын эртний анагаах ухааны дурсгал “Хуанди Нейжин” хэмээх нангиад бичигт умартын орны төөнө засал гэж тэмдэглэгдсэн бөгөөд хожим VIII зууны үед Төвөд анагаах ухааны өв болсон “Рашааны зүрхэн найман гишүүт нууц увдисын үндэс” зохиолын “Язгуурын үндэс”-ийн Монголын төөнө (хоржи мэза) гэж монголоос үүсэлтэй төөнөх эмчилгээний арга болохыг бүр тодорхой болгож, дорно дахинаа алдаршуулжээ.

Ийнхүү эмчилгээний домд мэргэжлийн салбарууд үүсч өргөжсөн тэр үеэс эмчилгээний дом эмпирик хандлагатай болж, түүхийн урт хугацаанд тэр чанараа хадгалсан байна [3].

Соёлын хөгжилтийн талаар Монгол үндэстэнгүүдэд ихээхэн дэвшил гарсан. XII зууны үед зарим аймгууд голдуу уйгар үсгийн цагаан толгойгоор монгол үгийг авиачлан бичсэн үсэг бичгийг хэрэглэхийн хамт зарим нь Хятад үсгийг хэрэглэж байжээ. Үүнээс өмнө бичиг үсэг гэж байсангүй. Хубилай цэцэн хан өөрийн зарлигаараа 1269 онд Пагва ламыг залж 42 цагаан толгойн үсэгтэй дөрвөлжин монгол үсгийг зохиолгожээ. Энэ дөрвөлжин монгол үсгийг Юан улсыг мөхтөл хэрэглэж байв. 1307 онд Чойжи-Одсэр уйгар үсгийн цагаан толгойгоор монгол үгийг авиачлан тэмдэглэдэг үсгийг нэлээд сайжруулан засч дүрэмжүүлжээ. Энэ бол өнөөг хүртэл хэрэглэж байгаа монгол үсэг болно.

Энэ үеэс бичигдэж эхэлсэн домын шившлэг, зан үйл, эмчилгээний аргуудыг эмхтгэсэн жижиг номуудыг “Хар домын судар”-ууд хэмээн нэрлэдэг. Д.Баттогтох (1991) өөрийн бүтээлдээ “Өвчнийг анагаах энэ эмчилгээ нь бөөгийн шашин, түүний зан үйлтэй холбоотой бөгөөд

өвчний ад зэтгэрийг алив нэг юмтай холбон түүнтэй эсрэгцэлдэх буюу нөхцөлдөх зүйлээр нь домнож, үйлддэг арга юм гэсэн” байдаг. Хар домын судруудын гол агуулга, эмчилгээний арга зүйн зарчмууд нь бусад 3 урсгалаас онцгой өөр, нүүдэлчдийн амьдрал, зан, дадалтай нягт уялдаатай байдаг хэмээжээ [4].

#### **Дүгнэлт:**

Бид судалгааны явцад олж тогтоосон эх сурвалж, баримт нотолгоондоо үндэслэн төвөд болон монголд дом гэдэг нь өөр утгууд илэрхийлдэг бөгөөд монгол дом нь балар эртний үеэс хүмүүсийн амьдрал ахуйд тохиолдож байсан эрүүл мэндийн асуудлаас үүдэн гарч боловсронгуй хөгжсөөр иржээ.

Эхний үедээ империк шинжтэй, тогтсон дараалал, ухамсартай үйлдэл бус байсны хөгжлийн явцад, ажиглалт, туршилтаар боловсронгуй болж, хөгжсөөр байжээ. Бүр цаашлаад эмч, домч эмэгтэйчүүд олширч байсны сацуу монгол домд мэргэжлийн чиг ялгаа үүсээд дом-домч, эм-эмч, бариа-бариагч, хануур- хануурч, засал-засалч, шарх-шархч гэдэг тусгай нэр томъёо бий болжээ.

#### **Ном зүй**

1. Пүрэвсүрэн Б. Монгол дом, УБ, Мөнхийн үсэг ХХК, 2005, х.7, 8, 11, 38-39, 42, 45
2. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь, Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол, УБ, 2005, х.36
3. Болд Ш., Амбага М., бусад. Монгол туургатны анагаах ухааны алдарт эмч, маарамба, мэргэдийн намтар. УБ, “Одсар Систем” ХХК, 1999, х.19
4. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх, УБ, ADMON PRINTING, 2006, х.119
5. Лувсан. Монгол эмийн судлал, Бээжин, Үндэстний хэвлэл, 1986, х.130
6. Тэрбиш Л. Төвөд – Монгол иж бүрэн толь бичиг, Улаанбаатар, Соёмбо принтинг ХХК, 2019, х.1356
7. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал, Улаанбаатар, Мөнхийн үсэг ХХК, 2014, х.132-236
8. Аминдаваа Ж. “Дом эмнэлэг”, Ухаалагчийн өврийн дэвтэр, 1968, х.22
9. Баттогтох Д. “Эмгэг согог бүхнийг эдгээн илааршуулагч эм дом, засал, төөнө, зурхай тарнийн судар оршвой”, УБ, 1991, х.13-43
10. Баттогтох Д. “Хар домын судрууд”, УБ, 1991, х.5-16
11. Пүрэвсүрэн Б., Мэндсайхан З. Хардом ардын бор арга /I хэвлэл/, УБ, 2003, х.19-272
12. Пүрэвсүрэн Б., Мэндсайхан З. Хардом ардын бор арга, УБ, 2006, х.21
13. Хөх хуцын увдис оршвой (Зохиогч тодорхойгүй, нийт 38 нүүр)
14. Авгаандондов Ш. Монгол хар домын судруудын чуулга, УБ, 1991, х.5-61
15. Жамъян Д. Монгол зурхай хүн судлал, УБ, 1990, х.4
16. Галбаабадраа Л. Уламжлалт анагаах ухааны дом засалд суралцагчдын гарын авлага, УБ, 2009, х.23

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:  
Анагаахын шинжлэх ухааны доктор,  
профессор Ч.Чимэдрагчаа*